


6. Магадлан итгэмжлэл

Магадлан итгэмжлэл модуль нь сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, сургалтын байгууллагын гишүүнчлэлийн мэдээллийг удирдсанаар ДБУМС-д нэгдсэн байдлаар магадлан итгэмжлэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, сургалтын бусад мэдээлэлтэй харьцуулсан дүн шинжилгээ хийх, магадлан итгэмжлэлийн мэдээллийг ашиглан шийдвэр гаргахад нь туслах зорилготой юм.



Магадлан итгэмжлэлийн мэдээлэл

№	Талбар	Тайлбар	Жишээ
Үндсэн мэдээлэл			
1.	Сургалтын байгууллага	Магадлан итгэмжилж байгаа сургалтын байгууллагыг сонгоно.	МУИС
2.	Магадлан итгэмжлэгч	Магадлан итгэмжлэгч байгууллагыг сонгоно.	БМИҮЗ
3.	Магадлан итгэмжлэлийн төрөл	Сургалтын байгууллагын, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн аль нь болохыг сонгоно.	Хөтөлбөр
4.	Гэрчилгээний дугаар	Магадлан итгэмжлэлийн гэрчилгээний дугаарыг оруулна.	20192001
5.	Итгэмжилсэн огноо	Магадлан итгэмжилсэн огноог оруулна. Хэрэв магадлан итгэмжлэх үйл явц хараахан дуусаагүй бол энэ мэдээллийг оруулахгүй.	2019/04/17
6.	Хугацаа дуусах огноо	Хүчинтэй хугацаа дуусах огноог оруулна. Хэрэв магадлан итгэмжлэх үйл явц хараахан дуусаагүй	2024/04/17

		бол энэ мэдээллийг оруулахгүй.	
7.	Төлөв	Магадлан итгэмжлэл аль шатандаа явж байгааг сонгоно.	Хүчинтэй
8.	Дүгнэлт	Шалгуурыг хэрхэн хангасан тухай дүгнэлтийг сонгоно.	Шийдвэр гаргалт
9.	Үе шат	Магадлан итгэмжлэл нь аль үе шатандаа явж байгааг сонгоно	
10.	Тушаал шийдвэр	Тушаал шийдвэрийн төрлийг сонгоно.	5 жилийн хугацаагаар магадлан итгэмжлэх
11.	Тушаал шийдвэрийн дугаар	Тушаал шийдвэр гаргасан тоот, дугаарыг тушаал шийдвэрийн нэрийн хамт оруулна. Хэрэв магадлан итгэмжлэх үйл явц хараахан дуусаагүй бол энэ мэдээллийг оруулахгүй.	Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 12 тоот тогтоол
12.	Тушаал шийдвэрийн огноо	Тушаал шийдвэр гарсан албан ёсны огноог оруулна. Хэрэв магадлан итгэмжлэх үйл явц хараахан дуусаагүй бол энэ мэдээллийг оруулахгүй.	2019/04/17
13.	Хүсэлтийн дугаар	Магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасан хүсэлтийн дугаарыг оруулна	17
14.	Тайлбар	Магадлан итгэмжлэлийн тухай тайлбарыг оруулна.	

Хөтөлбөрийн мэдээлэл-Хэрэв магадлан итгэмжлэлийн төрөл нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэл бол хөтөлбөр нэмэх үйлдлээр орж тухайн байгуулагын нийт хөтөлбөрөөс магадлан итгэмжилсэн хөтөлбөрүүдийг сонгоно. Ингэхдээ дээрх гэрчилгээнд хамаарах мэргэжлийн чиглэлийн тохирох хөтөлбөрүүдийг л сонгож өгнө.

1.	Хөтөлбөр	Сонгосон хөтөлбөрийн нэрийг харуулна.	Эрүүл мэндийн бодлого удирдлага /Доктор/
2.	Боловсролын түвшин	Сонгосон хөтөлбөрийн боловсролын түвшинг харуулна.	Докторын боловсрол
3.	Тайлбар	Хөтөлбөртэй холбоотой тайлбар оруулж болно.	